



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

### Эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Санхүүгийн зохицуулах Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Ард даатгал” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Ичинхорлоо овогтой Сэр-Одыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны даргын 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 47 дугаар тушаалын Булган овогтой Гантулгад холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ажиллахыг И.Сэр-Одод үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН